

СЭДЭВ 1



*Bonjour ! Hello !
Buon giorno ! Buenos dias !*

...
... *Сайн байна уу ?*

Франц хэл дэлхийд

Манай дэлхий дээр өнөөдөр ойролцоогоор 6 тэрбум (миллиард) хүн 200 гаруй улсад амьдарч байна. эдгээр улсын оршин суугчид бүгд өөр өөрийн ондоо хэлээр ярьдаг. Хэдэн зуун төрлийн хэл байдгаас зарим хэлээр зөвхөн хэдэн мянган хүн л харилцдаг байна.

Англи хэлийг олон улсын худалдаанд хамгийн өргөн хэрэглэдэг бол хятад хэлээр хамгийн олон хүн ярьдаг.

Дэлхий дээр 200 гаруй сая хүн франц хэлээр өдөр тутам ярьлгаас 60 сая хүн Францад, үлдсэн нь Белги Швейцари Канад болон бусад Африкийн хэдэн улсад байдаг.

Франц сургууль

Францад хүүхдүүд 16 нас хүртлээ суруульд сурах ёстой. хүүхдүүд эхлээд бага сургууль дараа нь дунд сургууль эцэст нь бүрэн дунд сургуулиар явдаг.

Цэцэрлэг 6-гаас доош насны хүүхдүүдийг хүлээн авах боловч заавал явах албагүй.

Гэхдээ цэцэрлэг хүүхдийг сургуульд ороход нь бэлддэг бөгөөд эцэг эхчүүдийг хүүхдүүдээ бүртгүүлэхийг зөвлөдөг. Бага сургуульд хүүхдүүд насанд хүрэгсэдийн ертөнцөд орох үлдсэн бүх мэдлэг олж авдаг : жишээ нь, унших бичих тоолох болон гадаад хэл сурах цахим тооцоолуур дээр ажиллах анхны мэдлэг зэрэг бусад янз бүрийн зүйлс сурдаг.

Тийм учраас хүүхдүүдээс хичээлдээ үргэлж явж цагтаа ирж байхыг шаарддаг. хэрэв нэг сурагч хичээлдээ ирэхгүй бол эцэг эхээсээ учир шалтгаанаа тоочсон уучлалын захиа авчрах ёстой.

Сургууль болгон дараалсан 5 ангитай ба тэдгээр нь боловсролын 5 шатны төвшинтэй нийцнэ. Жишээлбэл, 8 настай хүүхдийн ангийн хичээлийн хуваарь :

	ДАВАА	МЯГМАР	ПҮРЭВ	БААСАН
08-30	Франц хэл	Франц хэл	Франц хэл	Франц хэл
	Математик	Математик	Математик	Математик
10-00	ЗАВСАРЛАГА			
10-20	Математик	Математик	Математик	Математик
	Унших бичиг	Унших бичиг		
11-30	ӨДРИЙН ХООЛ			
01-30	Унших бичиг	Шинжлэх ухаан	Шинжлэх ухаан	Түүх
	Газар зүй	Цахим тооцоолуур	Усанд сэлэлт	Унших бичиг
03-00	ЗАВСАРЛАГА			ЗАВСАРЛАГА
03-20	Дуу хөгжим	Дүрслэх урлаг	Усанд сэлэлт	Биеийн тамир
			Яруу найраг	

Авчрах хэрэглэл ба хувиас :

- Бассейн : усны хувиас, усны малгай, алчуур
- Биеийн тамир : богино өмд, пүүз, майк футболка
- Сургуулийн гуанзны өдрийн хоол 5 : гар нүүрийн алчуур, шүдний сойз авчрах



Дараах асуултанд тохирох зөв хариултыг хүрээлнэ үү

1) Дэлхий дээр хамгийн олон хүн ярьдаг хэл аль нь вэ ?

франц

англи

хятад

2) Франц хэлээр зөвхөн Франц улсад ярьдаг уу ?

Тийм

Үгүй

3) Францад 4 настай хүүхэд заавал сургуульд явах ёстой юу ?

Тийм

Үгүй

$$\dots / 2 + \dots / 2 + \dots / 2 = \dots / 6$$

4) Хичээлийн хуваарийг сайтар ажиглана уу : завсарлага хэр удаан үргэлжилдэг вэ ?

40 минут

30 минут

20 минут

5) Долоо хоногийн аль өдөр унших бичгийн хичээл ордоггүй вэ ?

Даваа

Мягмар

Пүрэв

Баасан

6) Хэд дэх өдөр сурачид сургуульдаа усны хувцас, гар нүүрийн алчуур авчрах ёстой вэ ?

Даваа

Мягмар

Пүрэв

Баасан.

$$\dots / 2 + \dots / 2 + \dots / 2 = \dots / 6$$